



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 10 сарын 26 өдөр

Дугаар 98

Номгон

Монгол Улсын “Хөдөлмөрийн баатар”
цолоор шагнуулах хүний тодорхойлолт
өргөн мэдүүлэх тухай

Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын уугуул Гончигийн Лхаахүүг Монгол Улсын “Хөдөлмөрийн баатар” цолоор шагнуулахаар ирүүлсэн материалтай танилцаад ТЭМДЭГЛЭХ нь:

Гончигийн Лхаахүү нь Монгол Улсын Боловсролын салбарт 50 жил ажиллах хугацаандаа бага насны хүүхдийг Монгол хэл, Хичээнгүй бичиг, Цагаан толгойд эхлэн сурах чиглэлээр дагнан ажиллаж мэргэшсэн төдийгүй өөрийн чадвар, онол арга зүйн мэдлэгээ оюутан, багш нарт өвлүүлэн сургахад хүчин чармайлт гаргаж шавь нараа бэлтгэж ирсэн байна. Түүний анхны “Цагаан толгой” сурах бичиг 1982 онд хэвлэгдснээс хойш 2012 он хүртэл нэг жилд дунджаар 47000 хүүхэд нэгдүгээр ангид элсэн суралцаж 30 жилийн хугацаанд 1500000 гаруй хүүхэд энэ номоор билгийн нүдээ нээж эрдэм номын ариун замд орсон байдаг.


Бага боловсролын болон Монгол хэл уран зохиолын сургалтын агуулга арга зүйг боловсронгуй болгоход үнэтэй хувь нэмэр оруулж, хөдөө орон нутгийн багш нарыг хөгжүүлэх тэдний ур чадварыг нэмэгдүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулж яваа профессор юм. Түүний шавь нараас Монгол Улсын гавьяат 5, Урлагийн гавьяат зүтгэлтэн 2, эрдэмтэн доктор 10, олон арван Боловсролын тэргүүний ажилтан, ур чадварын улсын уралдааны тэргүүнүүд тодорсон нь ажлын амжилтыг илтгэж байна. Тиймээс Монгол Улсын Боловсролын салбарыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж буй Г.Лхаахүүгийн гавьяаг нь үнэлж Монгол Улсын “Хөдөлмөрийн баатар” цолоор шагнуулах саналыг дэмжих нь зүйтэй юм.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Монгол Улсын Боловсролын салбарын хөгжил цэцэглэлтэд хувь нэмрээ оруулж, олон жил, үр бүтээлтэй ажиллаж байгаа Монгол Улсын Боловсролын Их сургуулийн профессор, багшийн сургуулийн зөвлөх багш Г.Лхаахүүг Монгол Улсын “Хөдөлмөрийн

116090

баатар” цол тэмдгээр шагнуулахаар тодорхойлолтыг Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй.

ДАРГА  Ц.ОТГОНБАЯР

The image shows a red rectangular stamp with a central emblem. A handwritten signature in black ink is written across the stamp. The signature is written in Cyrillic and appears to be 'Ц.Отгонбаяр'. The words 'ДАРГА' (Chief) and 'Ц.ОТГОНБАЯР' (C. Otgonbayar) are printed in black text on either side of the signature.